УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-24/220

Харьцуулсан судалгаа

Захиалагч: УИХ-ын гишүүн Э.Одбаяр

Хянасан: ПСХХ-ийн захирал Д.Бумдарь (Ph.D)

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга П.Түмэнцэцэг

Судлаачид: О.Нарантуяа, Б.Мөнгөнсувд, Б.Уганжаргал

Улаанбаатар хот
2024

АГУУЛГА

УДИРТГАЛ 2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ 3
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ 8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН 8
ОЛОН УЛСЫН ТОДОРХОЙЛОЛТ, НЭР ТОМЬЁО 8
ХОЁРДУГААР БҮЛЭГ.АВСТРАЛИ, ГЕРМАН БОЛОН МОНГОЛ УЛСЫН 15
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА 15
2.1.Австрали Улс 15
2.2. Герман улс (ХБНГУ) 19
2.3.Монгол Улс 21
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 24

Хүснэгт 1. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголтыг анх хууль тогтоомждоо тусгасан улсууд 9
Хүснэгт 2. Зарим нэр томьёоны тайлбар 10
Хүснэгт 3. Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль шинээр баталсан улсууд 11
Хүснэгт 4. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн бүртгэгдсэн тоо, Монгол Улс, 2020-2023 он 22

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын захиалгаар “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн талаарх гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн нэр томьёо, тодорхойлолт, тус гэмт хэргийн субьект, хөөн хэлэлцэх хугацаа болон хүлээлгэх хариуцлагын талаар олон улсын болон гадаадын зарим орны туршлагыг өөрийн улстай харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн талаар олон улсын тодорхойлолт, нэр томьёоны тайлбарын талаар судлав. Мөн өндөр хөгжилтэй, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжоор зохицуулдаг Австрали улс, ХБНГУ (Герман улс)-ын туршлага, Монгол Улсын эрх зүйн орчны зохицуулалтыг тусгасан болно.

Судалгааны бүтэц: Судалгааны *нэгдүгээр бүлэгт* үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн нэр томьёо, тодорхойлолтын талаар, *Хоёрдугаар бүлэгт,* Австрали, Герман болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалсан болно.

Түлхүүр үг: *үндэслэлгүйгээр хөрөнгөжих, тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ, шударга бусаар хөрөнгөжих,*

Key words: *illicit enrichment, unexplained wealth, unjust enrichment,*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэсэн ухагдахуун нь олон төрлийн үзэл хандлагыг дагуулдаг бөгөөд зарим нь авлига болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хөрөнгө буцаах чухал арга хэрэгсэл гэж үзэж байхад, нөгөө талд эрх зүйн нийтлэг зарчмыг зөрчсөн ухагдахуун гэж үзэх хүмүүс ч байдаг байна.

2003 онд Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын конвенцын [1] үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай 20 дугаар зүйлд “оролцогч улс бүр хууль бусаар хөрөнгөжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байвал ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тооцоход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг Үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.” гэж тодорхойлсон хэдий ч дэлхийн өнцөг булан бүрд энэхүү ухагдахууныг хууль тогтоомждоо тусгасан хэлбэр нь эрс ялгаатай, харилцан адилгүй томьёололтой байна.

Тухайлбал, зарим улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжих явдлыг эрүүгийн хуулиар шийдвэрлэх ёстой гэж үзэж байхад, зарим нь энэ бол иргэний эрх зүйн журмаар шийдвэрлэх маргаан гэж үзсэн байна. Мөн, зарим улс үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомж нь зөвхөн төрийн албан тушаалтан (public official) болон авлигын гэмт хэрэгт л чиглэгдсэн байх ёстой гэж үзэж байхад, энэ төрлийн хууль тогтоомж нь мансууруулах бодистой холбоотой зэрэг бусад төрлийн гэмт хэрэгт ч өндөр ач холбогдолтой гэж үзэх хандлага ч байна.

“Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэдэг нэр томьёо хүртэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг нэр томьёо биш бөгөөд тухайн улсаасаа хамааран уг ойлголтыг “хууль бусаар хөрөнгөжих”, “үндэслэлгүйгээр ашиг хонжоо олох”, “шударга бусаар хөрөнгөжих”, “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ”, эсхүл “тайлбарлагдаагүй өмч олж авах” гэх мэтээр нэрлэж байна. (Нэр томьёоны тайлбарын дэлгэрэнгүйг Хүснэгт 2-оос үзнэ үү)

Дэлхийн 98 улс орны хууль тогтоомжид тусгасан тодорхойлолтыг судалсны үндсэн дээр үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай заалтыг үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хуваасан байна[2]. Үүнд:

- Хамгийн анхан шатны түвшинд үндэслэлгүйгээр хөрөнгөжих явдлыг **хууль ёсны орлогоор баталгаажиж зөвтгөгдөөгүй тийм хөрөнгө чинээг эзэмшиж үр шимийг хүртэх** асуудал гэж тодорхойлж болох юм. Хууль тогтоомжид хэрхэн томьёолж, хэрэглэх нь тухайн улсын тайлбараас ихээхэн хамаарах бөгөөд “хөрөнгө чинээ” болон “орлого” гэдгийг хууль тогтоомжид хэрхэн тусгаснаас шалтгаалах ажээ. Мөн, тус хуулийн “субъект” нь бүх хүн эсхүл тусгайлан тодорхойлсон бүлэг этгээд буюу төрийн албан хаагчаар хязгаарлагдаж байгаа эсэхээс хамаардаг байна.
- “тодорхой хэмжээний хөрөнгө чинээг эзэмших, үр шимийг хүртэх (enjoyment)” гэдэг нь **мөнгөн үнэ цэнэ бүхий зүйлийг** олж авах, хүлээн авах эсхүл ашиглахыг хэлнэ. Хамгийн өргөн цар хүрээгээр авч үзвэл олон улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжих ухагдахуунд “амьдралын хэв маяг”-т нөлөөлнө гэж тооцож болох мөнгөн (pecuniary) үнэ цэнэ бүхий аливаа зүйлийг зөвтгөж тайлбарлах боломжгүйгээр эзэмшиж үр шимийг хүртэж байгааг үндэслэлгүйгээр хөрөнгөжихөд хамруулдаг байна.

[1] Авлигын эсрэг НҮБ-ын конвенц https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760279163531&showType=1

[2] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 26 дахь тал

Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулийн субъектийн хувьд, хязгаарлагдмал хүрээнд албан тушаал хашиж байхдаа авлигын арга замаар хөрөнгөжсөн төрийн албан хаагч (public officials), өргөн цар хүрээгээр хүн бүрийг хамрах өргөн цар хүрээтэй байна. Мэдээж, төрийн албан хаагчийн тодорхойлолт тухайн улсын хууль тогтоомжоос хамааран харилцан адилгүй байх ч дийлэнх нь тус тодорхойлолтод нэлээд өргөн цар хүрээний субъектийг хамруулдаг. Тухайлбал, Австралийн иргэний хуульд “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл”-ийн субъект нь хэн ч байж болох бөгөөд ихэвчлэн мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдэд хэрэглэдэг байна. Харин Эрүүгийн хуульд төрийн албан хаагч болон төрийн өндөр албан тушаалтанд төрийн үйлчилгээний ажилтнууд, батлан хамгаалах, хууль хүчний байгууллагын албан хаагчид, гэрээ байгуулан томилогдсон төрийн албан хаагчид хамаарахаар зохицуулжээ.

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд, Улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуульдаа харилцан адилгүй хөөн хэлэлцэх хугацаа тавьдаг байна. Зарим улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй гэж хуульдаа тодорхой тусгасан байдаг бол зарим улс хуульдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж болох цаг хугацааны хатуу хязгаар тогтоосон байна. Тухайлбал, тухайн этгээд шууд эсхүл шууд бусаар эд хөрөнгөө ашигласаар байх тул үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь үргэлжилсэн гэмт хэргийн шинжтэй гэж олон орон тодорхойлсон байна. Судалгаанд авагдсан Австрали улсын Эрүүгийн хуульд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 6 жил байхаар заасан бол, Герман улсын Иргэний хуульд бусдын зардлаар хөрөнгөжсөн этгээд учирсан хохирлыг барагдуулах бөгөөд хариуцагч талд нэхэмжлэл гаргасан өдрөөс эхлэн 10 жил, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 30 жилийн дараа дуусна гэж тус тус заасан байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хүлээлгэх санкцын хувьд, дэлхийн улс орнуудад асар их ялгаатай байна. Энэ төрлийн хууль тогтоомжийн иргэний эрх зүйн санкц нь цэвэр мөнгөнд тулгуурласан байхад эрүүгийн эрх зүйн хуулиуд нь үүнээс гадна хорих ял, нэмэлт торгууль оногдуулдаг байна.

Иргэний хуулийн санкц: Иргэний хуулийн хүрээнд хариуцагчийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдвол түүнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үнийн дүнтэй нь тэнцэх иргэний өр төлбөрийг улсын орлого болгох шийдвэр гардаг. Жишээ нь, Баруун Австралид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төр хариуцагчийн эзэмшиж байгаа хөрөнгө чинээний хэмжээ нь түүний хууль ёсоор олж авсан хөрөнгө чинээнээс илүү байвал түүнд шүүхээс “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл”-ийг гардуулж, “хариуцагчид тус мэдэгдэлд дурдсан түүний тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний дүнтэй тэнцэх эд хөрөнгийг улсын орлого болгох үүрэг хүлээлгэдэг[3]” байна.

Эрүүгийн хуулийн санкц: Хэрэв сэжигтэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь эрүүгийн хуулийн хүрээнд нотлогдвол хорих ял болон/эсхүл торгууль ногдуулах зэрэг харьцангуй хатуу ял шийтгэл ногдуулдаг байна.

[3] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 48 дахь тал (Proceeds of Crime Act 1997 (as amended by the Proceeds of Crime Amendment Act No. 7 of 2005 and by the Proceeds of Crime (Amendment) Decree 2012 (Decree No. 61 of 2012)) (Fiji), Section 71F.)

Судалгаанд авагдсан зарим орны туршлага

Судалгаанд өндөр хөгжилтэй, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжоор хослуулан зохицуулдаг Австрали улс, ХБНГУ (Герман улс)-ын туршлага, Монгол Улсын эрх зүйн орчны зохицуулалтыг авч үзсэн болно.

Австрали улсын хувьд, тус улс нь 1995 онд Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь хууль бус гэж үзсэн бөгөөд 2000 онд Австралийн мужийн засгийн газар болох Баруун Австрали "тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл" гэх ухагдахууныг хуульд нэвтрүүлснээр шүүгдэгчийн "хууль ёсны хүрээнд олж авсан хөрөнгө чинээ"-ээс илүү байгаа дүнтэй тэнцэх мөнгөн төлбөрийг улсад төлөхийг шүүх тушаах боломжтой болжээ. Төрийн албан тушаалтанд хээл хахууль эсхүл авлигын ашиг тус амлах, санал болгох зэргийг гэмт хэрэгт тооцдог бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой харилцааг Үндсэн хууль, Эрүүгийн тухай хууль, Гэмт хэргийн тухай хууль, Иргэний хууль, Авлигын эсрэг хууль, Австрали улсын эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хуулиар зохицуулдаг.

Тус улсын хувьд, үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудлыг эрүүгийн болон иргэний хуулиар зохицуулдаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг "тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ" гэсэн агуулгаар авч үздэг бөгөөд Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хуулиар[4] зохицуулдаг. Эдгээр хуульд тухайн этгээдийн "хөрөнгө чинээ"-г бүрдүүлж байгаа эзэмшиж, өмчилж, захиран зарцуулж болох бүх эд хөрөнгө, хүлээн авсан бүх төрлийн үйлчилгээ, давуу байдал эсхүл ашиг хонжоо зэрэг өргөн хүрээг хамруулдаг. Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хууль (2002)-д тухайн этгээдийн бүх төрлийн өмч, хүлээн авсан үйлчилгээ, давуу байдал, ашиг хонжоог ч хамруулдаг байна.

Баруун Австралийн иргэний хуульд "тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл"-ийн субъект нь хэн ч байж болох бөгөөд ихэвчлэн мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдэд хэрэглэдэг байна. Харин Эрүүгийн хуульд төрийн албан хаагч болон төрийн өндөр албан тушаалтанд төрийн үйлчилгээний ажилтнууд, батлан хамгаалах, хууль хүчний байгууллагын албан хаагчид, гэрээ байгуулан томилогдсон төрийн албан хаагчид багтдаг.

<u>Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны хувьд,</u> Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 2-т үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг мөрдөн шалгах явц болон хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. Хэргийн оролцогч нараас шалтгаалан хөөн хэлэлцэх хугацааг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэхээр зохицуулжээ.

<u>Ял шийтгэлийн хувьд,</u> **т**ухайн хэргийн сэжигтэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь эрүүгийн хуулийн хүрээнд нотлогдвол хорих ял болон/эсхүл торгууль ногдуулах зэрэг харьцангуй хатуу ял шийтгэл ногдуулдаг. Иргэний хуульд хариуцагчийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдвол түүнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үнийн дүнтэй нь тэнцэх иргэний өр төлбөрийг улсын орлого болгох шийдвэр гардаг.

Герман улсын хувьд, тус улс нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хэн үйлдэж байгаагаас хамааран хариуцлага хүлээлгэх хууль, эрх зүйн орчин нь өөр өөр буюу Иргэний болон Эрүүгийн хуулиар зохицуулдаг. Иргэний хуулийн 812 дугаар зүйлд "хууль ёсны

[4] Criminal Proceeds Confiscation Act 2002 (as amended by the Criminal Proceeds Confiscation (Unexplained Wealth and Serious Drug Offender Confiscation Order) Amendment Act 2013) (Australia - Queensland).

үндэслэлгүйгээр бусдын зардлаар, бусдын гүйцэтгэлээр болон бусад хэлбэрээр ямар нэгэн зүйл олж авсан этгээд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй" гэж заасан. Харин төрийн албан хаагч авлигын гэмт хэрэгт, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн бол Эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг.

Төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгөх, авах (албан тушаалаа урвуулан ашиглах, хэн нэгэнд давуу байдал олгох) гэмт үйлдлийг Эрүүгийн хуулиар, иргэний "үндэслэлгүйгээр хөрөнгөжих"-тэй холбоотой харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд, Иргэний хуулийн 852 дугаар зүйлд бусдын зардлаар хөрөнгөжсөн этгээд учирсан хохирлыг барагдуулах бөгөөд хариуцагч талд нэхэмжлэл гаргасан өдрөөс эхлэн 10 жил, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 30 жилийн дараа дуусна гэж заажээ. Мөн Иргэний хуульд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн иргэн, түүнд гаргасан нэхэмжлэлийн харилцааг зохицуулдаг бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг 3 жил гэж заасан бөгөөд тодорхой хэрэг маргааны нөхцөл байдлыг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг 30 хүртэлх жил гэж заасан.

Ял шийтгэлийн хувьд, Эрүүгийн хуулийн 333 дугаар зүйлд зааснаар төрийн албан хаагч авлигын гэмт хэрэг үйлдсэн бол торгууль ногдуулах, хорих ял ногдуулдаг. Тухайлбал, Төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэг хүлээсэн албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэснийхээ төлөө өөртөө эсвэл бусдаас ашиг хүртэх, ашиг хүртээхийг шаардах, амлалт авах, ашиг хүртсэн тохиолдолд тухайн этгээдэд 3 жилээс илүүгүй ял шийтгэх эсвэл торгууль оногдуулна. Харин төрийн албан хаагчийн энэ үйлдлийг шууд мэдэгдвэл иргэн, хуулийн этгээдэд хариуцлагаас чөлөөлдөг.

Монгол Улсын хувьд, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд нарийвчлан заасан. Энэ нь Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын хуулиар харьяалан шалгах 12 төрлийн гэмт хэргийн нэг юм. Тухайн албан тушаалтан үндэслэлгүй хөрөнгөжсөн эсэхийг илрүүлэх ажил нь түүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаас эхэлдэг.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд "албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ" гэж тодорхойлсон. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субьектийн хувьд, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан буюу төрийн албан хаагч байхаар заасан байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тооцохоор зохицуулжээ. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 5 жил гэж заасан.

Мөн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.

Ял шийтгэлийн хувьд, 2022 онд Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах үүднээс үндсэн болон хүндрүүлэх

бүрэлдэхүүнээс торгох ялыг хасаж, хорих ялын хэмжээг нэмэгдүүлж, нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх өөрчлөлтүүдийг тусгасан бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хувьд үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасаж, нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан. Мөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.

Мөн үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хялбаршуулсан журмаар [5] хянан шийдвэрлэхгүй болсон.

[5] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэг. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН ТОДОРХОЙЛОЛТ, НЭР ТОМЬЁО

Энэхүү судалгааны онолын хэсгийг Эндрью Дорнбьererийн “Үндэслэлгүй хөрөнгөжилт-тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлагаас[6] ашигласан болно.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэсэн ухагдахуун нь олон төрлийн үзэл хандлагыг дагуулдаг. Зарим нь авлига болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хөрөнгө буцаах чухал арга хэрэгсэл гэж үзэж байхад, эрх зүйн нийтлэг зарчмыг зөрчсөн ухагдахуун гэж үзэх хүмүүс ч байна. Аливаа улс оронд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжийг анх танилцуулах оролдлого нь эрх зүйн эрс тэс чиг хандлагыг агуулсан маргаан үүсгэх нь элбэг. Үүний шалтгаан нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомж нь аливаа этгээд нь өөрийн хөрөнгө чинээ их хэмжээгээр нэмэгдсэнийг хууль ёсны орлогын эх үүсвэрийн хүрээнд үндэслэлтэй тайлбарлаагүй, эсвэл тайлбарлаж чадахгүй байгаа тохиолдолд түүнд хариуцлага ногдуулах эрхийг шүүхэд олгох бөгөөд ингэхдээ шүүх тусдаа суурь гэмт явдал үйлдэгдсэнийг эрүүгийн эсхүл иргэний эрх зүйн стандартаар нотлоогүй байсан ч ингэж хариуцлага ногдуулж болдогтой холбоотой юм.

Эрх зүйн энэхүү ухагдахууны эрс тэс үзэл хандлагын жишээг Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Бэлтгэл ажил (Travaux Prйparatoires)-ын “20 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” хэсгийг конвенцод оруулахтай холбоотой зохион байгуулсан хэлэлцүүлгийн үйл явцаас харж болно. Үндэслэлгүй хөрөнгөжилттэй холбоотой заалтын төслийн хэлэлцүүлэг хариуцсан хороонд танилцуулахад олон төлөөлөгч томоохон асуудал дэвшүүлжээ. Оросын Холбооны Улс (ОХУ) болон Европын Холбооны зарим гишүүн орнууд энэхүү заалтыг конвенцоос бүхэлд нь хасуулахаар “хүчтэй эсэргүүцэл” илэрхийлж байв. Гэвч, нөгөө талаас зарим төлөөлөгч тус заалтыг оруулах байр суурьнаасаа гажаагүй юм. Улмаар хэд хэдэн хэлэлцүүлэг өрнүүлсний эцэст хүрсэн шийдэл нь “20 дугаар зүйлийг батална, гэвч заавал биелүүлэх шаардлага тавихгүй” гэх нөхцөл байв.

Заавал хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн нөхцөлийг улс орнууд нь харилцан адилгүй авч хэрэгжүүлснээс эрх зүйн эл ухагдахуунтай холбогдох зөрөлдөөнтэй үзэл хандлага мөн харагдах ажээ. Нэг талаас Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг олон гишүүн орнууд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай зүйл, заалтыг хэрэгжүүлж, хууль тогтоомждоо суулгасан байна. Тухайлбал, 2007 онд Кени улс Авлигатай тэмцэх тухай хууль, 2010 онд Камбож улс Авлигын эсрэг хуулийг баталж, үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой зохицуулалтыг хийжээ. Гэтэл, бусад улс орнууд энэхүү эрх зүйн ухагдахууныг эрс эсэргүүцсэн байр сууриндаа бат зогсож, тэр ч байтугай эдгээр улсын шүүх гадаадын улс оронд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжид үндэслэсэн хөрөнгө буцаах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс татгалзсан тохиолдол ч байна.

Дэлхийн өнцөг булан бүрд энэхүү ухагдахууныг хууль тогтоомждоо тусгасан хэлбэр нь эрс ялгаатай, харилцан адилгүй томьёололтой байна. Тухайлбал, зарим улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжих явдлыг эрүүгийн хуулиар шийдвэрлэх ёстой гэж үзэж байхад зарим нь энэ бол иргэний эрх зүйн журмаар шийдвэрлэх маргаан гэж үзсэн байна. Мөн, зарим

[6] https://baselgovernance.org/sites/default/files/2023-04/illicit_enrichment_mongolian.pdf

улс үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомж нь зөвхөн төрийн албан тушаалтан (public official) болон авлигын гэмт хэрэгт л чиглэгдсэн байх ёстой гэж үзэж байхад, энэ төрлийн хууль тогтоомж нь мансууруулах бодистой холбоотой зэрэг бусад төрлийн гэмт хэрэгт ч өндөр ач холбогдолтой гэж үзэх хандлага ч байна. Тэр ч байтугай, улс орнууд тус ухагдахууны үндсэн тодорхойлолтыг хүртэл “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ (unexplained wealth)” эсхүл “шударга бусаар хөрөнгөжих” (unjust enrichment) гэх мэтээр хуульдаа харилцан адилгүй тусгасан байна.

Улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголтыг хууль тогтоомжоор зохицуулах оролдлогыг эртнээс хийж байжээ. Тухайлбал,

Хүснэгт 1. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголтыг анх хууль тогтоомждоо тусгасан улсууд

Улсын нэр	Зохицуулалт
Хонконг (1950)	Улс албан ёсны цалин хөлс нь эзэмшиж байгаа хөрөнгө эсхүл амьдралын хэв маягтай нь нийцгүй байгааг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулна.
Филлипин (1955)	Төрийн албан тушаалтны эзэмшиж байгаа эд хөрөнгө нь түүний хууль ёсны орлоготой “илт нийцэхгүй байгаа” тохиолдолд “илэрхий хууль бусаар олж авсан гэж дүгнэж” болох бөгөөд тухайн этгээд нь хөрөнгөө хууль ёсны эх үүсвэрээс хэрхэн бий болгосон тухай тайлбар гаргаж, тайлбарыг “шүүх хангалттай гэж дүгнэсэн” тохиолдолд л хууль ёсных гэж үзнэ гэж тодорхойлжээ.
Пакистан (1960)	Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульдаа үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцжээ. Ингэхдээ, “мэдэгдэж байгаа орлогын эх үүсвэртэй нь үл нийцэх өмч (property)” эзэмшиж байгаа бол хорих ял, торгууль, өмч хураах ял оногоно.
Египет (1975)	Төрийн албан хаагчийн “хөрөнгө чинээний өсөлт нь” түүний хууль ёсны эх үүсвэртэй нийцэхгүй байгаа тохиолдолд “хууль бус ашиг” (illegal gain) гэж тооцно.
Сенегал (1981)	Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж төрийн албан хаагч “өөрийн эзэмшиж байгаа өмч эсхүл амьдралын хэв маягаа хууль ёсны эх үүсвэрийн хүрээнд хэрхэн бий болгосноо нотолж чадахгүй байгаа” нөхцөл байдлыг хэлнэ гэж тодорхойлжээ.
Бруней (1982)	“тайлбарлагдаагүй өмч эзэмших”-ийг гэмт хэрэгт тооцож, өөрийн хууль ёсны орлоготой нийцээгүй өмч эзэмшиж, амьдралын хэв маягтай байгаа төрийн албан хаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно гэж заасан.

Түүх сөхвөл, 1996 онд үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголттой холбоотой томоохон ахиц олон улсын түвшинд гарсан нь Авлигын эсрэг Америк тивийн улс хоорондын конвенц (IACAC)-д уг ойлголтыг тусгасан анхны олон талт гэрээ хэлцэл болсон явдал байв. Уг конвенцын 9 дүгээр зүйлд “төрийн албан хаагч албан тушаал хаших явцад түүний хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн хууль ёсны орлогын хүрээнд үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байх...” гэж тодорхойлжээ.

2003 онд, Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Африкийн Холбооны конвенц (AUCPCC) үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай зүйл ангийг тусгасан хоёр дахь олон талт гэрээ болжээ. Тус конвенцын 1 дүгээр зүйлд “... төрийн албан хаагч эсхүл аливаа хувь хүний хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн орлогын хүрээнд үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байх” гэж тодорхойлжээ.

2003 онд, Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай 20 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: оролцогч улс бүр хууль бусаар хөрөнгөжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байвал ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тооцоход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг үндсэн хууль болон эрх зүйн

тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ. Энэхүү үзэл санааг улс орнууд дотоодын хууль тогтоомждоо харилцан адилгүй тодорхойлсон байна. Хүснэгт 3-аас үзнэ үү.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь зарим талаар үүнтэй холбоотой чиглэл тогтоож байгаа боловч улс орнууд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомждоо өөрийн гэсэн ялгамжтай тодорхойлолт оруулсан байгаагаас конвенцын 20 дугаар зүйл нь нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт биш болох нь харагдана. Тухайлбал, тус конвенцод үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг “төрийн албан хаагч” (public official) “санаатайгаар” хөрөнгөө “ноцтой хэмжээгээр” (significant) нэмэгдүүлж, үүнийгээ өөрийн хууль ёсны орлогын хүрээнд үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа явдал гэж тодорхойлж байхад олон улс орон тус ухагдахууныг ерөнхий байдлаар тодорхойлж, хөрөнгөжих явдал нь “санаатай” эсхүл “нэлээд хэмжээтэй” байх, зөвхөн төрийн албан хаагч үйлдсэн байх зэргийг нарийвчлан заагаагүй байна.

“Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” (illicit enrichment), “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ” (unexplained wealth), “шударга бусаар хөрөнгөжих” (unjust enrichment) гэсэн нэр томьёонуудыг яг ижил, эсхүл тун төстэй нөхцөл байдлыг тодорхойлоход ижил утгатайгаар ашигласаар байна. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэдэг нэр томьёо хүртэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг нэр томьёо биш бөгөөд тухайн улсаасаа хамааран уг ойлголтыг “хууль бусаар хөрөнгөжих”, “үндэслэлгүйгээр ашиг хонжоо олох”, “шударга бусаар хөрөнгөжих”, “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ”, эсхүл “тайлбарлагдаагүй өмч” олж авах гэх мэтээр нэрлэж байна. Харин Үндэслэлгүй хөрөнгөжилт гарын авлагын судлаачид үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг **“хууль ёсны эх үүсвэрээр баталгаажиж зөвтгөгдөөгүй (not justified) хөрөнгө чинээг эзэмших”** гэж тодорхойлжээ[7].

Хүснэгт 2. Зарим нэр томьёоны тайлбар

Нэр томьёоны тодорхойлолт	
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	Хууль ёсны орлогоор баталгаажиж зөвтгөгдөөгүй хөрөнгө чинээг (wealth) эзэмших, үр шимийг хүртэх (enjoyment).
Хөрөнгө чинээ эзэмших/үр шимийг хүртэх	Мөнгөн үнэ цэнэ бүхий зүйлийг олж авах, хүлээн авах, ашиглах.
Хууль ёсны орлогоор баталгаажиж зөвтгөгдөөгүй (not justified)	Тухайн хөрөнгө чинээг хууль ёсны эсхүл гэмт хэргийн бус гаралтай болохыг батлах нотлох баримт байхгүй.
Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль	Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн (дээр дурдсан тодорхойлолтын хүрээнд) болох нь тогтоогдсон гэж шүүх үзсэн тохиолдолд эрүүгийн эсхүл иргэний санкцыг оногдуулах эрхийг шүүхэд олгож байгаа бөгөөд уг санкцыг ногдуулахын тулд тусдаа үйлдэгдсэн эсхүл уг зүйл ангид холбогдох суурь гэмт үйлдлийг нотлох шаардлага тавиагүй хууль тогтоомж дахь аливаа зүйл заалт.
Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хууль	Эрүүгийн гэмт хэргийг тодорхойлсон, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу хэрэгжиж, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг аливаа үндэслэлгүй хөрөнгөжилтийн талаарх хууль.
Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний хууль	Иргэний захирамжийн процессын хэлбэртэй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу хэрэгжиж, хариуцагчаар нөхөн төлбөр

[7] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 16 дахь тал

	төлүүлэх хэлбэрийн санкцыг агуулсан аливаа үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль.
Шалгуур тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль	Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийн талаарх дээр дурдсан тодорхойлолтод багтах боловч тусдаа үйлдэгдсэн суурь аливаа гэмт үйлдэл гарсан болох талаар "үндэслэл бүхий сэжиг" эсхүл "үндэслэл бүхий итгэл үнэмшил" бүхий нотлох баримтыг гаргаж өгөхийг төрөөс шаарддаг хууль тогтоомжийг хэлнэ.

Сүүлийн 20 жил буюу Авлигын эсрэг НҮБ-ын конвенц 2003 онд батлагдсанаас хойш олон улс орон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомжийг нэвтрүүлсэн ч мэргэжилтнүүдийн хувьд энэхүү хуулийг хэрхэн хэрэглэх тал дээр тодорхойгүй байдал байсаар байна. Үүний улмаас, олон улс орон энэхүү хуулийг хэрэглэхдээ ихээхэн болгоомжтой хандаж байна. Тухайлбал, Танзани улс 2007 онд үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай болсон ч тус хуулийн зүйл ангиар хэрэг хянан шийдвэрлэх анхны тохиолдол 2019 онд гарчээ.

Хүснэгт 3. Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль шинээр баталсан улсууд[8]

Улсын нэр	***Зохицуулалт***
Кени (2007)	Авлигатай тэмцэх хууль тогтоомждоо "тайлбарлагдаагүй хөрөнгө"-тэй холбоотой иргэний эрх зүйд суурилсан захирамж гаргах зохицуулалт оруулсан.
Камбож (2010)	Төрийн албан хаагч өөрийн хөрөнгө чинээ нэмэгдсэнийг "хууль ёсны орлогын эх үүсвэртэйгээ нийцүүлэн" тайлбарлаж чадахгүй байх тохиолдлыг хамрахаар зохицуулсан.
Джибути (2011)	Төрийн албан хаагч өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол 15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх боломжтой.
Эквадор (2014)	Аливаа этгээд нь "өөртөө эсхүл гуравдагч этгээдэд зориулан хөрөнгө чинээгээ үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн бол Эрүүгийн хуулиар ял шийтгэл ногдуулна.
Молдав (2002)	Төрийн албан хаагч нь "өөрийнх нь орлогоос их хэмжээгээр давсан", "хууль ёсны хүрээнд олж авах боломжгүй" үнэ цэнэ бүхий хөрөнгө эзэмшиж байгаа нь тогтоогдвол түүнд эрүүгийн ял шийтгэл ногдуулна.
Австралийн өөр найман мужийн засгийн газар[9]	"Тайлбарлагдаагүй" хөрөнгөтэй холбогдох иргэний эрх зүйн захирамж гаргах өөрийн гэсэн зохицуулалтын хувилбарыг нэвтрүүлсэн.

Улс орнууд нь **"хууль ёсны орлогоор баталгаажиж зөвтгөгдөөгүй** (not justified)**"** гэдэг агуулгыг харилцан адилгүй байдлаар тайлбарласан ч энэ нь ерөнхийдөө тухайн этгээдийн эзэмшиж байгаа эд хөрөнгө нь хууль ёсны эсхүл гэмт хэргийн бус гаралтай болохыг батлах нотлох баримт (цалингийн орлого, хууль ёсны бизнесийн үйл ажиллагааны ашиг орлого, тэтгэврийн орлого, өв залгамжлал, бэлэглэл эсхүл банкнаас авсан зээл гм) байхгүй байх тохиолдлыг хамрах юм.

Зарим улсад "үндэслэлгүйгээр хөрөнгөжих" болон "шударга бусаар хөрөнгөжих" гэсэн нэр томьёог нэгэн утгаар, харилцан орлуулан хэрэглэдэг. Гэвч, "шударга бусаар хөрөнгөжих" гэх нэр томьёог иргэний эрх зүйд хувийн нэхэмжлэлийн хүрээнд нөхөн төлбөр гаргуулах утгаар хэрэглэдэг. Энэ нь нэг тал тэднийг хохироон нөгөө талын шударга бусаар олсон ашгийг буцаан шаардах процесс юм.

[8] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 25 дахь тал

[9] Австрали нь Холбооны эрх зүйн тогтолцоотой бөгөөд зэрэгцэн орших 9 шүүхийн харьяаллаас бүрддэг: Холбооны хуулийн нэг харьяалал болон найман муж/нутаг дэвсгэрийн хуулийн харьяалалтай.

Дэлхийн улс орнуудын 98 хууль тогтоомжид тусгасан тодорхойлолтыг судалсны үндсэн дээр үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай заалтыг улс орнуудын хуулийн тайлбараас үл хамааран үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хувааж болохоор байна[10]. Үүнд:

- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголтын хүрээнд, "тодорхой хэмжээний хөрөнгө чинээг эзэмших, үр шимийг хүртэх" гэдэг нь **мөнгөн үнэ цэнэ бүхий зүйлийг** олж авах, хүлээн авах эсхүл ашиглахыг хэлнэ. Тухайн этгээдийг үндэслэлгүйгээр хөрөнгөжихөд хүргэх олж авсан, хүлээн авсан эсхүл ашигласан тодорхой зүйл нь ч улс орнууд хооронд ихээхэн ялгагдах ажээ. Ихэнх улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг хязгаарлагдмал байдлаар тодорхойлж, үүндээ аливаа этгээд нь биет ба/эсхүл биет бус хөрөнгийг хууль ёсны орлогоор баталгаажуулж зөвтгөж чадахгүй байгаа тохиолдлыг зөвхөн хамруулахаар заасан (жишээ нь, шүүгдэгч нь олон тооны орон сууц олж авсан эсхүл банкны дансны үлдэгдэл нь огцом нэмэгдсэн) байдаг.
- Улс орнууд нь **"хууль ёсны орлогоор баталгаажиж зөвтгөгдөөгүй"** гэдэг агуулгыг харилцан адилгүй байдлаар тайлбарласан ч энэ нь ерөнхийдөө тухайн этгээдийн эзэмшиж байгаа эд хөрөнгө нь хууль ёсны эсхүл гэмт хэргийн бус гаралтай болохыг батлах нотлох баримт (цалингийн орлого, хууль ёсны бизнесийн үйл ажиллагааны ашиг орлого, тэтгэврийн орлого, өв залгамжлал, бэлэглэл эсхүл банкнаас авсан зээл гм) байхгүй байх тохиолдлыг хамрах юм.

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хууль эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай 98 улс байна. Үүнд: 36 нь Ази-Номхон далайн бүс нутагт, 35 нь Африк тивд, 25 нь Америк тив, хоёр нь Европ тивд байна. Эдгээр хууль нь эх газрын болон Ром-Германы эрх зүйн бүл давамгайлсан улсад харьяалагдаж байгаа бол 35 нь эх газрын эрх зүйн бүл давамгайлсан улсад, 18 нь холимог тогтолцоотой улсынх байна[11]. Эдгээр хууль тогтоомжийн 78 нь эрүүгийн эсхүл шалгуур тогтоосон үндэслэлгүйгээр хөрөнгөжих эрүүгийн хуулийн ангилалд, 18 нь иргэний хуулийн ангилалд хамаарч байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субьект

Үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хуулийн субьектийн хувьд хязгаарлагдмал хүрээнд албан тушаал хашиж байхдаа авлигын арга замаар хөрөнгөжсөн төрийн албан хаагч (public officials), өргөн цар хүрээгээр хүн бүрийг хамрах өргөн цар хүрээтэй байна. Төрийн албан хаагчийн тодорхойлолт тухайн улсын хууль тогтоомжоос хамааран харилцан адилгүй байх ч дийлэнх нь тус тодорхойлолтод нэлээд өргөн цар хүрээний субъектийг хамруулдаг. Тухайлбал, Танзани Улсад "төрийн албан хаагч"-г "хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх, захиргааны, улс төрийн, цэргийн, аюулгүй байдлын, хууль сахиулах, орон нутгийн удирдлагын эсхүл хуулиар тогтоосон бусад албан тушаал хашдаг төрийн чиг үүргийг хэрэгжүүлж эсхүл төрийн үйлчилгээг үзүүлж буй аливаа этгээд" гэж тодорхойлжээ.

Харин Баруун Австралийн үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний хууль болох "тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл"-ийн субъект нь хэн ч байж болох бөгөөд ихэвчлэн мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдэд хэрэглэдэг байна. Мадагаскар улсад "хуулийн этгээд нь мэдсээр байж хууль

[10] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 26 дахь тал
[11] Мөн тэнд, 45 дахь тал

бусаар хөрөнгөжсөн этгээдээс эд хөрөнгө хүлээн авсан бол 20 хүртэл жилийн хугацаанд арилжааны үйл ажиллагааг нь хориглох” хүртэл санкц ногдуулдаг байна.


Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа

Улс орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжилтийн тухай хууль тогтоомждоо харилцан адилгүй хөөн хэлэлцэх хугацаа тавьдаг байна. Зарим улс орон үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй гэж хуульдаа тодорхой тусгасан байдаг ч зарим улс хуульдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж болох цаг хугацааны хатуу хязгаар тогтоосон байна[12]. Тухайлбал, тухайн этгээд шууд эсхүл шууд бусаар эд хөрөнгөө ашигласаар байх тул үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь үргэлжилсэн гэмт хэргийн шинжтэй гэж олон орон тодорхойлсон байна. Жишээ нь, Алжир, Буркина Фасо, Мавритани улс үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь “хууль бус хөрөнгийг эзэмших буюу шууд эсхүл шууд бусаар ашиглах шинж чанартай тул үргэлжилсэн гэмт хэрэг юм” гэж хуульдаа тодорхойлжээ.

Зарим улс орон өөр байх суурь илэрхийлж, үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай зүйл заалтад цаг хугацааны хязгаарлалт тогтоосон байдаг. Жишээ нь, Хаитигийн Үндсэн хуулиар хөөн хэлэлцэх хугацааг 20 жил гэж тодорхойлжээ. Харин Мали улс онцлог байр суурьтай байх бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг үргэлжилсэн гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрсөн ч тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн илэрсэн мөчөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэж заасан.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт хүлээлгэх санкц

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулиудын санкц нь бусад хуулийн адил дэлхийн улс орнууд хооронд асар их ялгаатай байдаг. Мэдээж, энэ төрлийн хууль тогтоомжийн иргэний эрх зүйн санкц нь цэвэр мөнгөнд тулгуурласан байхад эрүүгийн эрх зүйн хуулиуд нь үүнээс гадна хорих ял, нэмэлт торгууль оногдуулдаг байна.



Иргэний хуулийн санкц: Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний хуулийн хүрээнд хариуцагчийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдвол түүнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үнийн дүнтэй нь тэнцэх иргэний өр төлбөрийг улсын орлого болгох шийдвэр гардаг. Жишээ нь, Баруун Австралид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төр хариуцагчийн эзэмшиж байгаа хөрөнгө чинээний хэмжээ нь түүний хууль ёсоор олж авсан хөрөнгө чинээнээс илүү байвал түүнд шүүхээс “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний

[12] Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, 60 дахь тал

мэдэгдэл”-ийг гардуулж, “хариуцагчид тус мэдэгдэлд дурдсан түүний тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний дүнтэй тэнцэх эд хөрөнгийг улсын орлого болгох үүрэг хүлээлгэдэг” байна.

Эрүүгийн хуулийн санкц: Хэрэв сэжигтэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуулийн хүрээнд нотлогдвол хорих ял болон/эсхүл торгууль ногдуулах зэрэг харьцангуй хатуу ял шийтгэл ногдуулдаг байна.

Хорих ял: Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуульд сэжигтэн нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдвол хорих ял оногдуулах санкцыг тусгасан байна. Жич, эдгээр хуулийн дийлэнх нь хорих ялыг заавал ногдуулах шийтгэл гэж тодорхойлоогүй ч торгуулийн ял дээр нэмэлтээр эсхүл торгуулийн оронд ногдуулж болно гэж тодорхойлжээ. Жишээ нь, Угандад, хэрэв сэжигтэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн болох нь тогтоогдвол “Арав хүртэл жил хорих эсхүл хоёр зуун дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэмдэгтээс хэтрэхгүй торгууль төлөх эсхүл эдгээрийн аль аль шийтгэлийг ногдуулна” гэж заажээ.

Хорих ял нь улс орноосоо хамааран асар их ялгаатай байна. Жишээ нь, Мексикт үндэслэлгүйгээр хөрөнгөжих зүйл ангиар шийтгэгдсэн этгээдэд зөвхөн гурван сар хорих ял ногдуулж байхад Жибути эсхүл Молдавт гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд 15 жил, Малайзад 20 хүртэл жилийн хорих ял ногдуулдаг байна.

Торгууль: Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуулиар ял шийтгэл ногдуулсан этгээдэд хорих ялын оронд эсхүл үүн дээр нэмээд торгууль ногдуулахаар тусгасан байна. Жишээ нь, Сьерра Леонд шүүхээр гэм буруу нь тогтоогдвол 30 сая хүртэл леонийн торгууль, Танзанид 10 сая хүртэл танзани шиллинг төлөх торгуулийг тус тус ногдуулдаг байна. Мөн түүнчлэн, Египетэд “хууль бус ашиг хонжоо” олсон этгээдэд “хууль бус ашиг хонжоог буцаан төлүүлээд” нэмээд “тус хууль бус ашиг хонжоотой тэнцэх торгууль төлөх” шийтгэл ногдуулдаг ажээ.

Захиргааны санкц: Улс орнууд нь үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай эрүүгийн хуулиар шийтгэгдсэн төрийн албан хаагчид нэмэлт шийтгэл оногдуулдаг бөгөөд тодорхой хугацаанд эсхүл бүр мөсөн төрийн албанд томилогдох эрхийг хязгаарладаг байна. Тухайлбал, Монгол Улсад ял шийтгэл авсан төрийн албан хаагчид төрийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасдаг. Антигуа ба Барбудад ял шийтгэл авсан төрийн албан хаагчийг төрийн албанд томилогдох эрхийг 7 хүртэл жилээр хасаж, тэтгэврийн аливаа хөтөлбөрт хамрагдах эрхийг хязгаарладаг байна. Үүнтэй адилаар Эль Сальвадорт албан тушаалтан нь 10 хүртэл жил төрийн албанд томилогдох эрхийг хасдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд ***хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагаа:*** Хорих ял, торгууль, захиргааны шийтгэлээс гадна, энэ төрлийн эрүүгийн хуулийн хүрээнд үндэслэлгүй хөрөнгөжсөн зүйл ангиар шийтгэгдсэн этгээд нь хууль бусаар олж авсан хөрөнгөө буцаан өгөх үүрэгтэй байдаг. Энэ төрлийн нөхөн төлбөрийн захирамж гаргах механизмууд нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Зарим хууль тогтоомжийн хүрээнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хөрөнгөө эргүүлэн өгч, үүнд торгуулийг оруулан тооцдог байхад үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн дүн болон торгуулийг тус тусад нь тооцоолон төлүүлдэг улсууд ч байна. Гэхдээ бусад улсын хуулиар үндэслэлгүй олсон хөрөнгө чинээг ногдуулсан бусад аливаа торгуулиас тусад нь ч тооцдог. Жишээ нь, Танзани, Сьерра Леоны хууль тогтоомжийн хүрээнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь нотлогдвол нөхөн төлөх хөрөнгийн дүн дээр нь торгуулийг тусад нь тооцоолж төлүүлдэг байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.АВСТРАЛИ, ГЕРМАН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

2.1.Австрали Улс

Австрали улс нь авлигын эсрэг тэмцэлд хатуу чанд хууль, эрх зүйн орчин бүрдүүлсэн улс юм. Улс орны хөгжил цэцэглэлт, ард иргэдийн итгэлцлийг хангах үүднээс авлигатай тэмцэх нь тэдний хувьд чухал асуудал болдог.

1995 онд Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь хууль бус гэж үзсэн бөгөөд 2000 онд Австралийн мужийн засгийн газар болох Баруун Австрали "тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл" гэх ухагдахууныг хуульд нэвтрүүлснээр шүүгдэгчийн "хууль ёсны хүрээнд олж авсан хөрөнгө чинээ"-ээс илүү байгаа дүнтэй тэнцэх мөнгөн төлбөрийг улсад төлөхийг шүүх тушаах боломжтой болсон байна. Энэ нь нэгд, иргэний эрх зүйн процесст суурилсан. Хоёрт, хуулиар авлигатай хамааралтай орлогын талаар төрийн албан хаагчийг шалгахаас гадна тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ эзэмшиж байгаа "ямар ч хүнийг" шалгаж болох зохицуулалт оруулсан явдал байв.

Австрали улс нь холбооны эрх зүйн тогтолцоотой бөгөөд Австралийн өөр найман мужийн засгийн газар нь "тайлбарлагдаагүй" хөрөнгөтэй холбогдох иргэний эрх зүйн захирамж гаргах өөрийн гэсэн зохицуулалтын хувилбарыг нэвтрүүлсэн байна.

Хамтын нөхөрлөлийн болон төрийн албан тушаалтанд хээл хахууль эсхүл авлигын ашиг тус амлах, санал болгох зэргийг гэмт хэрэгт тооцдог бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Үндсэн хууль;
- Эрүүгийн тухай хууль;
- Гэмт хэргийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Авлигын эсрэг хууль;
- Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хууль[13].

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудал нь авлигын гэмт хэргүүдийн нэг бөгөөд тус улсад авлигын эсрэг олон хууль тогтоомж үйлчилдэг, эдгээр хуулиуд нь төрийн албан хаагчдын авлига, хувийн хэвшлийн авлига, олон улсын хэмжээний авлига зэрэг өргөн хүрээг хамардаг. Австралийн гэмт хэргийн комиссийн тухай хууль (1984)[14]-иар авлигын эсрэг үндэсний хэмжээний агентлаг болох Австралийн гэмт хэргийн комиссыг байгуулж, түүний үйл ажиллагааг зохицуулдаг. Комисс нь авлигын эсрэг мөрдөн байцаалт явуулж, хууль хүчний байгууллагуудтай хамтран ажилладаг.
Харин Шударга байдлын комиссын хуулиар[15] холбооны засгийн газрын албан хаагчдын авлигын эсрэг хяналтын байгууллагыг 2018 онд байгуулжээ.

Авлигын эсрэг хуулиар Австралийн засгийн газар төрийн албан дахь ноцтой буюу системчилсэн авлигын үйлдэлийг илрүүлж, шалгаж, мэдээлдэг бие даасан агентлаг буюу

[13] Criminal Proceeds Confiscation Act 2002 (as amended by the Criminal Proceeds Confiscation (Unexplained Wealth and Serious Drug Offender Confiscation Order) Amendment Act 2013) (Australia - Queensland).
[14] Australian Crime Commission Act 1984
[15] Integrity Commission Act 2018

“Авлигатай тэмцэх үндэсний хороо” (The Independent Commission Against Corruption (ICAC)[16])-г байгуулан ажиллаж байна.

Тус улсын хувьд, үндэслэлгүйгээр хөрөнгөжих асуудлыг эрүүгийн болон иргэний хуулиар зохицуулдаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ” гэсэн агуулгаар авч үздэг бөгөөд Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хуулиар зохицуулдаг. Зарим заалтыг дурдвал:

11.Тайлбарлаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл гаргуулах хүсэлт гаргах нь
(1) Улсын Ерөнхий прокурор эсхүл Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх хороо нь тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл гаргуулах хүсэлтийг шүүхэд гаргаж болно.
…

12.Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл гаргах нь
(1) Шүүх 11(1)-д заасан хүсэлтийг хянан хэлэлцээд хариуцагчийн нийт хөрөнгө чинээний хэмжээ нь түүний хууль ёсны дагуу олж авсан хөрөнгө чинээний хэмжээнээс илүү байх магадлалтай бол хариуцагч нь тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ эзэмшиж байна гэж зарлах ёстой.

(2) Хариуцагч эсрэгээр нотлоогүй бол хариуцагчийн хөрөнгө чинээнд хамаарах аливаа өмч, үйлчилгээ, давуу байдал, үр шимийг хууль бусаар олж авсан гэж үзнэ.

(3) Шүүхийн авч хэлэлцэх асуудлыг хязгаарлахгүй ба шүүхээс хариуцагч нь тайлбарлагдаагүй хөрөнгө чинээтэй эсэхийг тогтоохын тулд хариуцагчийн тодорхой хугацааг хамрах эсхүл бүх цаг үеийн орлого, зарлагын хэмжээг харгалзан үзэж болно.
…

13.Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний үнэлгээг хийх нь
(1) Хариуцагчийн тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний хэмжээг дараах хоёр зүйлийн ялгавраар тодорхойлно:
(a) хариуцагийн хөрөнгө чинээний нийт үнэлгээ;
(b) хариуцагчийн хууль ёсны дагуу олж авсан хөрөнгө чинээний хэмжээ.
…

14.Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл, үр дагавар
Шүүхээс тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл гаргасан тохиолдолд хариуцагч түүнд заасан тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний үнэлгээ болох мөнгөн дүнг улсад төлөх үүрэг хүлээнэ.

Австралийн Квинслэндын Дээд шүүх Гэмт хэргийн гаралтай орлогыг хураан авах тухай хуулийн дагуу тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ (мөн хуульд тухайн этгээдийн хууль ёсоор олсон хөрөнгө чинээнээс хэтэрсэн хөрөнгө чинээ хэмээн тодорхойлжээ)-тэй холбогдох иргэний захирамж гаргадаг байна. Гэвч, энэхүү захирамжийг шүүх зөвхөн тухайн этгээд нь “нэг эсхүл хэд хэдэн онц ноцтой гэмт хэрэгт оролцсон”, эсхүл тухайн этгээд нь холбогдох өмч нь гэмт хэргийн гаралтайг мэдсэн эсвэл тийм гэж сэжиглэж байсан, үгүйгээс үл хамааран “хэн нэгний ноцтой гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагаанаас үүссэн өмчийг сайтар магадлалгүйгээр олж авсан” гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд гаргана.

Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн субьект: Баруун Австралийн иргэний хуульд “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл”-ийн субъект нь хэн ч байж болох бөгөөд ихэвчлэн мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдэд хэрэглэдэг байна.

Харин Эрүүгийн хуульд төрийн албан хаагч болон төрийн өндөр албан тушаалтанд төрийн үйлчилгээний ажилтнууд, батлан хамгаалах, хууль хүчний байгууллагын албан

[16] https://www.icac.nsw.gov.au/about-the-nsw-icac The Independent Commission Against Corruption

хаагчид, гэрээ байгуулан томилогдсон төрийн албан хаагчдыг багтаасан байна. Үүнд парламентын гишүүд, шүүхийн ажилтнууд, засаг дарга нар ч багтдаг байна.

Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний хууль тогтоомжууд нь маш өргөн цар хүрээний хөрөнгө чинээг хамардаг. Эдгээр хуульд тухайн этгээдийн "хөрөнгө чинээ"-г бүрдүүлж байгаа эзэмшиж, өмчилж, захиран зарцуулж болох бүх эд хөрөнгө, хүлээн авсан бүх төрлийн үйлчилгээ, давуу байдал эсхүл ашиг хонжоо зэрэг маш олон төрлийн зүйлсийг дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг.

Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураан авах тухай хуульд тухайн этгээдийн бүх төрлийн өмч, хүлээн авсан үйлчилгээ, давуу байдал, ашиг хонжоог ч хамруулдаг байна. Тухайлбал, Эрүүгийн гэмт хэргийн гаралтай өмчийг хураах тухай хуульд хувь хүний хөрөнгө чинээнд дараах зүйлсийг хамааруулахаар заажээ. Үүнд:

- Энэхүү хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө эсхүл дараа нь тухайн хүний эзэмших болсон бүх өмч
- Тухайн этгээд бодитоор хянадаг бүх өмч (энэ хууль хүчин төгөлдөр болж эхлэхээс өмнө эсхүл дараах үеийг хамаарна)
- Тухайн этгээд бусдад бэлэглэсэн бүх төрлийн өмч (энэ хууль хүчин төгөлдөр болж эхлэхээс өмнө эсхүл дараах үеийг хамаарна)
- Хэрэглэсэн эсхүл хаясан (жич, өдөр тутмын амьдралд шаардагдах хоол хүнс, хувцас хунар, бусад хэрэглээний зүйлс орохгүй) хэрэглээний зүйлс, хэрэглээний бараа бүтээгдэхүүн, удаан эдэлгээтэй барааг оруулаад тус хуулийг хүчин төгөлдөр болж эхлэхээс өмнө эсхүл дараа олж авсан бусад бүх өмч
- Тухайн этгээдийн хүсэлт эсхүл зааврааар гуравдагч этгээдийн олж авсан (энэ хууль хүчин төгөлдөр болж эхлэхээс өмнө эсхүл дараах үеийг хамаарна) бүх өмч, үйлчилгээ, давуу байдал, ашиг хонжоо
- Эд зүйлийг хууль ёсны дагуу олж авсан эсэх, түүнд хэрэг үүсгэсэн эсхүл тухайн гэмт хэрэгт шийтгүүлсэн эсэхээс үл хамааран бүтээгдэхүүн, олон нийтийн нэвтрүүлэг, телевиз радиогийн нэвтрүүлэг болон хэвлэлийн үнэ цэнэ нь тухайн хүн хөрөнгө хураах гэмт хэргийг үйлдэхэд оролцсон оролцооноос хамааралтай эсхүл оролцоогоор бий болсон Австралид эсхүл өөр улс оронд тухайн этгээд эсхүл гуравдагч этгээдийн аливаа бүтээгдэхүүн, олон нийтийн нэвтрүүлэг, телевиз радиогийн нэвтрүүлэг эсхүл бусад хэвлэлийг арилжааны зорилгоор ашиглах замаар олж авсан үнэ цэнэ бүхий аливаа зүйл.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 2-т үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг мөрдөн шалгах явц болон хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. Хэргийн оролцогч нараас шалтгаалан хөөн хэлэлцэх хугацааг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэхээр зохицуулжээ.

Ял шийтгэл ба торгууль: Тухайн хэргийн сэжигтэн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь эрүүгийн хуулийн хүрээнд нотлогдвол хорих ял болон/эсхүл торгууль ногдуулах зэрэг харьцангуй хатуу ял шийтгэл ногдуулдаг. Мөн корпорацын хээл хахууль, хууль бус тэтгэмж, үндэслэлгүйгээр хөрөнгөжих талаарх хариуцлагын талаар заасан.

1. Хээл хахууль өгөх

Төрийн өндөр албан тушаалтанд хээл хахууль өгөх тохиолдолд

- Шийтгэлийн дээд хэмжээ нь 100,000 торгуулийн нэгж (одоогоор 18 сая AUD-тай тэнцэх);
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хууль бус тэтгэмжийн үнийг гурав дахин нэмэгдүүлэх;

- Эсвэл өмнөх жилийн корпорацын жилийн эргэлтийн 10 хувийг торгууль ногдуулах.

2. Авлигын шинжтэй тэтгэмж санал болгох

Төрийн өндөр албан тушаалтанд авлигын шинжтэй тэтгэмж санал болгох эсхүл олгох тохиолдолд 1500 хүртэлх торгуулийн нэгж (одоогоор 270,000 AUD-тай тэнцэх)

3. Корпорац буюу Аж ахуйн нэгжийн хариуцлага

Хувь хүний зан үйл нь тэдний ажлын хүрээнд байсан тохиолдолд компанийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

- Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдах албан тушаалтнууд санаатай болон санамсаргүй/болгоомжгүй үйлдлүүдийг зөвшөөрсөн, үйлдсэн бол;
- Гэмт хэргийг мэдсээр байж гэмт хэргийг мэдээлээгүй бол;
- Байгууллага нь хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаарддаг аж ахуйн нэгжийн соёлыг бий болгож чадаагүй бол;
- Хуурамч нягтлан бодох бүртгэлийн гэмт хэрэг;
- Санаатайгаар хуурамч нягтлан бодох бүртгэлийн гэмт хэрэг үйлдсэн бол 18 сая AUD-тай тэнцэх хэмжээний торгууль, тэтгэмжийн үнийг 3 дахин нэмэгдүүлэх, эсхүл байгууллагын жилийн эргэлтийн 10 хувиар торгуулах;
- Болгоомжгүйгээс хуурамч нягтлан бодох бүртгэлийн гэмт хэрэг үйлдсэн бол 9 сая AUD-оос их хэмжээний торгууль, тэтгэмжийн үнийн дүнтэй тэнцэх торгуулийг тус тус ногдуулна.

Эрүүгийн тухай хуульд заасанчлан хувь этгээд болон аж ахуйн нэгжийн хувьд хээл хахууль өгөх, санал болгох зэрэг гэмт хэрэгтэй холбоотой шийтгэлийг тусгасан бөгөөд х**увь хүний хувьд** 10 хүртэлх жил хорих, эсхүл 10 мянга хүртэлх торгуулийн оноо буюу 8 сая AUD-тай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах бол **авлигын шинжтэй ашиг тус, хөрөнгө санал болгох** гэмт хэрэгт 5 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл 300 хүртэлх торгуулийн оноо буюу 54 мянган сая AUD-тай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэж заасан.

Харин **иргэний хуульд** хариуцагчийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдвол түүнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үнийн дүнтэй нь тэнцэх иргэний өр төлбөрийг улсын орлого болгох шийдвэр гардаг. Жишээ нь, Баруун Австралид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төр хариуцагчийн эзэмшиж байгаа хөрөнгө чинээний хэмжээ нь түүний хууль ёсоор олж авсан хөрөнгө чинээнээс илүү байвал түүнд шүүхээс “тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний мэдэгдэл”-ийг гардуулж, “хариуцагчид тус мэдэгдэлд дурдсан түүний тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний дүнтэй тэнцэх эд хөрөнгийг улсын орлого болгох үүрэг хүлээлгэдэг[17]” байна.

Австралийн Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай холбооны түвшний иргэний хуульд шүүгдэгчийн нийт хөрөнгө чинээний хэмжээг тооцоолохдоо “бүх цаг үед” түүний эзэмшиж, хяналтдаа байлгаж эсхүл захиран зарцуулсан өмчийг оруулна гэж заажээ. Тус хуулийн Тайлбар тунхаг бичигт (Explanatory Memorandum) “бүх цаг үед” гэдгийг “хамтын нөхөрлөлийн орнуудын тайлбарлагдаагүй хөрөнгө чинээний тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацааг хамарна”[18] гэж ойлгох бөгөөд энэ нь тухайн хууль үйлчилж эхлэхээс өмнө худалдаж авсан өмчийг ч хамарна гэсэн үг гэж тайлбарлажээ. Энэ үзэл санааг Баруун Австралийн Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай иргэний хуульд мөн адил хэлбэрээр тусгасан бөгөөд тус заалтад “тухайн этгээдийн хууль үйлчилж эхлэхээс өмнө эсхүл дараа худалдан авсан өмч,

[17] Criminal Property Confiscation Act 2000 (Australia - Western Australia) Sections 10-14.
[18] Explanatory Memorandum, Crimes Legislation Amendment (Unexplained Wealth And Other Measures) Bill 2014 (Australia - Federal).

үйлчилгээ, эдэлсэн давуу тал эсхүл олсон ашиг хонжоо хэлбэртэй тайлбарлагдаагүй хөрөнгө чинээ хамаарна” гэж тусгажээ.

2.2. Герман улс (ХБНГУ)

Транспарэнси олон улсын байгууллагаас жил бүр авлигын төсөөллийн индексийн үнэлгээг зарлахдаа байр суурь, санал асуулга, нотлох баримтаар судалгаа явуулж, улс орны засаг, төрийн байгууллагын авлигын төсөөллийг 16 эх сурвалж ашиглан гаргадаг байна. ХБНГУ нь 2023 оны авлигын төсөөллийн индексээр 180 орноос 9 дүгээр байрт жагсаж, нийт 78 оноо авсан байна.[19]

Герман улс нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хэн үйлдэж байгаагаас хамааран хариуцлага хүлээлгэх хууль, эрх зүйн орчин нь өөр өөр байна. Өөрөөр хэлбэл, Герман улс үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Иргэний болон Эрүүгийн хуулиар зохицуулдаг. Иргэний хуулийн 812 дугаар зүйлд “хууль ёсны үндэслэлгүйгээр бусдын зардлаар, бусдын гүйцэтгэлээр болон бусад хэлбэрээр ямар нэгэн зүйл олж авсан этгээд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Үүнээс үзвэл тухайн хөрөнгөө хууль ёсных гэдгийг нотолж чадахгүй, хууль бусаар хөрөнгө эзэмшиж байгааг **үндэслэлгүй хөрөнгөжих гэнэ**. Харин төрийн албан хаагч авлигын гэмт хэрэгт, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн бол Эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдэг нь хэн нэгэн бусдын хөдөлмөрөөр, бусдын зардлаар хөрөнгөжих ёсгүй бөгөөд Иргэний хуулийн дагуу үндэслэлгүй хөрөнгөжсөн тухай нэхэмжлэлийг гаргахдаа дараах зүйлсийг анхааран авч үзнэ. Үүнд:

- **Хөрөнгөжих**- тухайн этгээд ямар нэгэн байдлаар мөнгө, эд бараа, үйлчилгээ гэх мэт янз бүрийн байдлаар ашиг хүртсэн байх;
- **Хөрөнгөжилтийг бууруулах**-тухайн этгээдийн олсон ашиг хэмжигдэхүйц, өөрөөр хэлбэл тухайн этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгө үнэ бүхий байх;
- **Бусдын зардлаар ашиг олох**- үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь хэн нэгэнд хохирол учруулсан эсвэл нэхэмжлэгчийн гаргасан зардалтай тохирч байх ёстой. Энэ нь тухайн этгээдийн хууль бусаар олсон орлого болон хохирогч, нэхэмжлэгчийн гаргасан зардалтай зайлшгүй тохирч байх ёстой.
- **Хөрөнгөө нотлох**- тухайн этгээдийн эзэмшиж байшаа хөрөнгө нь хууль ёсны, гэрээ, хэлцлийн дагуу бол үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх нэхэмжлэл гаргах эрхгүй.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хянан хэлэлцэх журмын хувьд, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг дэлхийн улс орнуудын эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг бол Герман улсын хувьд Иргэний хуулиар шийдвэрлэж байна.

Төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгөх, авах (албан тушаалаа урвуулан ашиглах, хэн нэгэнд давуу байдал олгох) гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн 331-338 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэдэг бол Иргэний хуулийн 26 дугаар бүлгийн 812-822 дугаар зүйлд иргэний “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-тэй холбоотой харилцааг зохицуулах заалтыг оруулсан байдаг. Тухайлбал, Эрүүгийн хуульд төрийн албан хаагч авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд дараах зохицуулалтыг хийсэн байдаг. Үүнд:

[19] Corruption Perception Index, https://www.transparency.org/en/countries/germany

Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэг 331 дүгээр зүйл. Ашиг хүртэх

1) Төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэг хүлээсэн албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэснийхээ төлөө өөртөө эсвэл бусдаас ашиг хүртэх, ашиг хүртээхийг шаардах, амлалт авах, ашиг хүртсэн тохиолдолд тухайн этгээдэд 3 жилээс илүүгүй ял шийтгэх эсвэл торгууль оногдуулна.
2) Европын Холбооны шүүхийн гишүүн, арбитрч, шүүгчид өөртөө эсвэл бусдад давуу байдал олгож, хахууль өгөхийг шаардах, хахууль өгөх амлалт авах, тэдэнд давуу байдал олгож ашиг хүртсэн бол 5 жилээс илүүгүй хорих эсвэл мөнгөн торгууль оногдуулна.
3) Төрийн албан хаагч эрх мэдлээ ашиглан өөрт нь ашиг хүртээхийг шаардсан тохиолдолд тухайн төрийн албан хаагчийн энэ үйлдлийг шууд мэдэгдвэл иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй.

Эрүүгийн хуулийн 332 дугаар зүйл. Авлига авах

1) Төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэг бүхий албан хаагч, Европын Холбооны албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэсний төлөө эсвэл хэрэгжүүлэхийн тулд бусдаас хахууль өгөхийг шаардах, хахууль өгөхийг хүлээн зөвшөөрөх, улмаар хахууль авсан бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ. Үйлдсэн гэмт хэрэг нь хүндэвтэр бол 3 хүртэлх жилийн хорих ял шийтгэх эсвэл торгууль ногдуулна.
2) Европын Холбооны шүүхийн гишүүн, арбитрч, шүүгчид ажил үүргээ гүйцэтгэсний төлөө эсвэл албан үүргээ гүйцэтгэхдээ өөртөө эсвэл бусдад давуу байдал олгож, хахууль өгөхийг шаардах, хахууль өгөхийг дэмжих, амлалт авах үйлдэл гаргаж шүүгчийн үүрэг хариуцлагаа зөрчсөнөөр 1 жилээс 10 жил хүртэлх ял шийтгэнэ.
3) Төрийн албан хаагч ирээдүйд хийх үйлдлийнхээ төлөө хахууль өгөхийг шаардах, амлалт авах, хахууль авахыг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн тохиолдолд энэ зүйлийн (1), (2) хэсэгт заасан үйлдлүүд хэрэгжсэнд тооцно:
    1.Хахууль авч үүргээ зөрчих;
    2.Өөрийн албан үүргээ давуу байдлаа болгож бусдыг хясан боогдуулах.

Эрүүгийн хуулийн 333 дугаар зүйл. Авлига өгөх

1) Төрийн албан тушаалтан, Европын Холбооны албан тушаалтан, төрийн тусгай албан хаагчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсний төлөө өөртөө эсвэл бусдад авлига өгөхийг санал болгох, өгөхийг амлах, эсвэл өгсөн бол тухайн этгээдийг 3 хүртэлх жилээр хорих ял шийтгэх эсвэл торгууль оногдуулна.
2) Европын Холбооны шүүхийн гишүүн, арбитрч, шүүгчид хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэсний төлөө эсвэл ирээдүйд гүйцэтгэхэд нь авлига өгөхийг санал болгох, өгөхийг амлах, эсвэл өгсөн бол тухайн этгээдийг 5 хүртэлх жилээр хорих ял шийтгэх эсвэл торгууль оногдуулна.
3) Эрх бүхий байгууллага нь өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд авлига өгөхийг хүлээн зөвшөөрөх, энэ үйлдлийг нь шууд эрх бүхий байгууллагад мэдэгдсэн бол эрүүгийн хэргийн хариуцлага хүлээлгэхгүй.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Иргэний хуулиар зохицуулдаг. Иргэний хуулийн 852 дугаар зүйлд “Бусдын зардлаар хөрөнгөжсөн этгээд учирсан хохирлыг барагдуулах хуулийн хариуцлага хүлээнэ. Энэ хэргийн хөөн хэлэлцэх

хугацаа нь хариуцагч талд нэхэмжлэл гаргасан өдрөөс эхлэн 10 жил, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 30 жилийн дараа дуусна" гэж заасан.

Мөн Иргэний хуульд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн иргэн, түүнд гаргасан нэхэмжлэлийн харилцааг зохицуулдаг байна. Үүнд: нэхэмжлэл гаргах хамрах хүрээ, нэхэмжлэл гаргах, хохирол барагдуулах, хариуцлага тооцох, үндэслэлгүй хөрөнгөжихөөс урьдчилан сэргийлэх зэрэг бүх зохицуулалтыг оруулсан байдаг. Түүнчлэн энэ хуульд хөөн хэлэлцэх хугацааг 3 жил гэж заасан байдаг бөгөөд тодорхой хэрэг маргааны нөхцөл байдлыг харгалзан үзэж хөөн хэлэлцэх хугацааг 30 хүртэлх жил гэж заасан байна.

2.3.Монгол Улс

Манай улсын хувьд, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд "Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр[20] нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж заасан. Энэ нь Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын хуулиар харьяалан шалгах 12 төрлийн гэмт хэргийн нэг юм. Тухайн албан тушаалтан үндэслэлгүй хөрөнгөжсөн эсэхийг илрүүлэх ажил нь түүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаас эхэлдэг.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд "албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ" гэж тодорхойлсон бөгөөд Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалтыг баталсан. Үүнд:

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Албан тушаалтны ХАСХОМ-ийг АТГ-аас бүтэн жилийн туршид төлөвлөгөөт болон бусдаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийдэг. Сүүлийн жилүүдэд

[20] Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "их хэмжээ" гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

нийтийн албан тушаалтнууд оффшор бүс ашиглаж хууль бусаар хөрөнгө нуух, төр, төсвийн хөрөнгийг угаан хувьдаа ашиглах явдал их гарч байгаатай холбоотойгоор хяналт шалгалтын үйл ажиллагаанд олон улсын зарим нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, гадаад дотоод мөнгөн гуйвуулга, хэрэглээний их зардал, өндөр дүнтэй худалдан авалтын эх үүсвэр зэргийг хянан үздэг.

ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар илрүүлсэн үндэслэлгүй хөрөнгөжих нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг учраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын байгууллагын хяналтан дор хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхээр шийдвэрлэнэ. 2020-2023 онд 1245 албан тушаалтны ХАСХОМ-ийг нарийвчлан шалгасан, үүнээс 221-д нь хуулийн дагуу хариуцлага тооцуулж, сахилгын арга хэмжээ авахуулжээ. Энэ мэт зөрчлийн шинжтэй үйлдлээс гадна “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр 117 албан тушаалтан шалгагдсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр нийт 25 албан тушаалтныг нарийвчлан шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлжээ[21].

Монгол Улсад сүүлийн дөрвөн жилийн хугацаанд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг 24 бүртгэгдсэн байна.

Хүснэгт 4. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн бүртгэгдсэн тоо, Монгол Улс, 2020-2023 он

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн бүртгэгдсэн тоо				
Аймаг, нийслэл	**2020**	**2021**	**2022**	**2023**
Улсын дүн	7	10	9	24
Хангайн бүс	1	1		5
Баянхонгор				1
Булган				1
Орхон	1	1		3
Төвийн бүс	1	2	3	6
Говьсүмбэр		1		2
Дархан-Уул				4
Дорноговь	1	1	1	
Өмнөговь			1	
Сэлэнгэ			1	
Улаанбаатар	5	7	6	13

Эх сурвалж:1212.mn

<u>Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд</u>, Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл[22] тооцохооор зохицуулжээ. Мөн хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхэлнэ.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс хамаараад харилцан адилгүй байхаар зохицуулжээ. Эрүүгийн хуулийн 1.10-т 1 жил, 3 жил, 5 жил, 12 жил, 20 жил гэсэн 5 өөр хөөн хэлэлцэх хугацааг тухайн гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэлийн хэмжээг харгалзан тогтоосон байна.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн нь тогтоогдсон бол дараах ял оногдуулахаар заасан. Үүнд:

- Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж

[21] https://iaac.mn/post/159585
[22] Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- Үнэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна.

Ял шийтгэлийн хувьд, 2022 онд Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах үүднээс үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасаж, хорих ялын хэмжээг нэмэгдүүлж, нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, авлигын гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх өөрчлөлтүүдийг тусгасан бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хувьд үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасаж, нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан. Мөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.

Мөн үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй болсон.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага, Эндрью. Дорнбьерер, 2021, Монгол хэл https://baselgovernance.org/sites/default/files/2023-04/illicit_enrichment_mongolian.pdf https://baselgovernance.org/publications/illicit-enrichment-guide-laws-targeting-unexplained-wealth
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан https://www.1212.mn/
- Авлигатай тэмцэх газар https://iaac.mn/
- Авлигатай эсрэг хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928
- Эрүүгийн хууль https://legalinfo.mn/mn/detail/11634

Австрали улс

- Independent Commission Against corruption https://www.icac.nsw.gov.au
- https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/journals/MelbULawRw/2004/24.html
- Criminal Proceeds Confiscation Act 2002 (as amended by the Criminal Proceeds Confiscation (Unexplained Wealth and Serious Drug Offender Confiscation Order) Amendment Act 2013) (Australia - Queensland) https://www.legislation.qld.gov.au/view/pdf/asmade/act-2013-021
- Australian Crime Commission Act 1984 https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Bills_Legislation/Bills_Search_Results/Result?bId=r1640
- Integrity Commission Act 2018 https://www8.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/legis/act/consol_act/ica2018258/notes.html
- https://www.globalcompliancenews.com/anti-corruption/handbook/anti-corruption-in-australia/
- Illicit Enrichment: A Guide to Laws Targeting Unexplained Wealth https://baselgovernance.org/publications/illicit-enrichment-guide-laws-targeting-unexplained-wealth
- Criminal Code act 1995 https://www.legislation.gov.au/C2004A04868/2022-11-10/text

ХБНГУ

- Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт гарын авлага., 2022 он., Б.Өнөрмаа, Б.Галдаа
- ХБНГУ-ын Иргэний хууль, https://www.gesetze-im-internet.de/bgb/BGB.pdf
- ХБНГУ-ын Эрүүгийн хууль, https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p3275
- Герман дахь Авлигын эсрэг үйл ажиллагаа, https://www.globalcompliancenews.com/anti-corruption/handbook/anti-corruption-in-germany/
- Үндэслэлгүй хөрөнгөжилт., Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага., 2021 он.